



100-р хэсэг, тугуйн хэвцэл  
оны 03 дугаар сарын 19  
№11 /632/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

361

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

364

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

368

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн нэрэмжит  
тэтгэлэг хүртээх тухай**

**Цөмийн энергийн комиссын  
дүрэм батлах тухай**

**Хэрэглэгчийн эрхийг  
хамгаалах үндэсний  
хөтөлбөрийг батлах тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

98.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг хүртээх тухай	Дугаар 08	361
99.	Зэрэг дэв олгох тухай	Дугаар 09	363
100.	Ринчиний Нарангэрэлийг албан тушаалд томилгох тухай	Дугаар 10	364

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

101.	Цөмийн энергийн комиссын дүрэм батлах тухай	Дугаар 369	364
102.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг батлах тухай	Дугаар 371	368

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 01 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар  
хот

#### Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг хүртээх тухай

"Боловсролын тухай" Монгол Улсын хуулийн 43 дугаар зүйлийн 2.9 дэх заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан "Сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам"-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

2009-2010 оны хичээлийн жилд хавсралтад дурьдсан дараах нэр бүхий оюутан, сурагчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийг хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010  
оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн  
08 тоот зарлигийн хавсралт

1. Бат-Эрдэнийн Мөнхболд - МУИС-ийн Газар зүй, геологийн сургуулийн Байгаль ашиглалт, хяналт үнэлгээний 3-р анги
2. Хүчитбаатарын Мөнгөн - МУИС-ийн Эрдэс материалын химийн 4-р анги
3. Сумьяагийн Батсүрэн - МУИС-ийн Математик, компьютерийн сургуулийн программ хангамжийн инженерийн 4-р анги
4. Боргилнулууны Хүрэлтулга - МУИС-ийн Физик, электроникийн сургуулийн хэрэглээний геофизикийн 4-р анги
5. Баянжаргалын Өлзийсайхан - МУИС-ийн НШУС-ийн магистрант
6. Сүрэнхоролын Түмэндэмбэрэл - ШУТИС-ийн Цахилгаан холбооны 3-р анги
7. Дондовцэрэнгийн Ёндонноров - ШУТИС-ийн Уул уурхайн сургуулийн маркшейдерийн 2-р анги
8. Ганбаатарын Оюун-Эрдэнэ - ШУТИС-ийн Барилгын инженер, архитектурын сургуулийн барилгын бүтээц адлэлийн технологийн 2-р анги
9. Батболдын Болормаа - ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургууль, Хувцас дизайны 4-р анги
10. Р.Баасанхүү - ЭМШУИС-ийн харъяа Говь-Алтай аймаг дахь АУ-ны коллеж
11. Гүрбадамын Үнэнбат - ЭМШУИС-ийн АУС-ийн А 601-р хэсгийн оюутан
12. Цэвэгжавын Баярбат - ЭМШУИС-ийн Хүний их эмчийн 6 дугаар курс
13. Болдбаатарын Мөнхтулга - МУБИС-ийн байгалийн ухааны багшийн 3-р анги
14. Батбаярын Хонгормаа - МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын 2-р анги
15. Төмөр-Очирын Базаргүр - МУБИС-ийн бага боловсролын багшийн 2-р анги
16. Төмөр-Очирын Ууганбаатар - МУБИС-ийн Математик статистикийн сургуулийн 3 дугаар анги
17. Пүрэвжаргалын Лхамдэгд - ХААИС-ийн газрын кадастрын анги



- 18. Гунгаабаярын Амаржаргал - ХААИС-ийн агрономийн 3-р анги
- 19. Мянгарсүрэнгийн Одончимэг - ХААИС-ийн Мал эмнэл зүйн 4-р анги
- 20. Манлайбаатарын Болдбаяр - БХИС-ийн Удирдлагын технологийн сургуулийн хими технологийн инженерийн 3-р анги
- 21. Одгэрэлийн Алтангэрэл - БХИС-ийн Удирдлагын технологийн сургуулийн радио электроникийн инженерийн 2-р анги
- 22. Галсангийн Батбаяр - БХИС-ийн Удирдлагын технологийн сургуулийн нийгмийн удирдлагын 3-р анги
- 23. Гансүхийн Наранбат - ХЦДС-ийн Сэтгэл судлалын ЗД ангийн сонсогч
- 24. Сайнжаргалын Ням-Очир - ҮБТДС-ийн багш дасгалжуулагчийн анги
- 25. Бямбын Түвшинбат - ИЗИС-Хууль зүйн сургууль, эрх зүйн 4-р анги
- 26. Энхтөрийн Агиймаа - ИЗИС-Чингис Соосэ-ОУХС, ОУХ ажилтны 3-р анги
- 27. Мөнхбатын Уранцэцэг - Цагдаагийн академийн сонсогч
- 28. Жаргалсайханы Жамбалдагва - Улаанбаатар Эрдэм судлал дээд сургууль Олон улсын эрх зүйн 5-р анги

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

2010 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Зэрэг дэв олгох тухай**

"Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, "Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2, 4 дэх заалтыг үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ нь:**

Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд "Тэргүүн түшээ" зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 01 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

### Ринчиний Нарангэрэлийг албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Ринчиний Нарангэрэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөхөөр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 23-ний өдөр

Дугаар 369

Улаанбаатар  
хот

### Цөмийн энергийн комиссын дүрэм батлах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 10.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цөмийн энергийн комиссын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 265 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

## ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цөмийн энергийн комисс (цаашид "комисс" гэх)-ын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулахад оршино.

1.2. Комисс нь үйл ажиллагаандаа энэ дүрэм болон цөмийн энергийн хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

### Хоёр. Комиссын удирдлага, бүрэлдэхүүн

2.1. Комисс нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Комиссын дарга нь Ерөнхий сайд, орлогч дарга нь цөмийн энергийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга байна.

### Гурав. Комиссын үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Комиссын үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Комиссын хуралдаанд комиссын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд таслах эрхтэйгээр оролцоно. Хуралдааныг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

Шаардлагатай гэж үзвэл цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр судалгаа, шинжилгээний үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн шалтгаан, эрдэмтэд болон холбогдох бусад этгээдийг оролцуулан хуралдааныг өргөтгөсөн хэлбэрээр хийж болно.

3.2. Хуралдааныг комиссын дарга даргална. Комиссын даргын түр эзгүй үед хуралдааныг комиссын орлогч дарга даргална. Комиссын дарга, орлогч дарга нар нэгэн зэрэг түр эзгүйд комиссын даргын үүрэг болгосноор



комиссын аль нэг гишүүн хуралдааныг даргална.

3.3. Комиссын нарийн бичгийн дарга нь комиссын дотоод ажлыг хариуцна. Нарийн бичгийн дарга нь комиссын хуралдаанаар хэлэлцэх асуудлын болтгэлийг хангаж, хуралдааны тэмдэглэлийг хөтөлнө. Хуралдааны тэмдэглэлд комиссын дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Комиссын даргын түр эзгүйд хуралдааны тэмдэглэлд хуралдаан даргалагч гарын үсэг зурна.

3.4. Комисс нь хууль тогтоомж, энэ журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоол гаргана. Шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

3.5. Комиссын гаргасан шийдвэрийг цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

3.6. Комиссын ажлын албаны үүргийг Цөмийн энергийн газар гүйцэтгэнэ.

### **Дөрөв. Комиссын эрх, үүрэг**

4.1. Комисс нь Цөмийн энергийн тухай хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

4.1.1. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн салбарт хамтран ажиллах стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, тэдэнтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах асуудлаар санал, дүгнэлт гаргах;

4.1.2. цөмийн төхөөрөмж барих газрын байршлыг сонгох болон цөмийн хаягдал, ашиглагдсан түлшийг булшлах асуудлаар санал, дүгнэлт гаргах;

4.1.3. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах асуудлаар цөмийн энергийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлагад үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд хяналт тавих;

4.1.4. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн

энерги ашиглах, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослын хор уршгийг арилгах талаар яаралтай авах арга хэмжээний талаархи саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

4.1.5. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах;

4.1.6. нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд түүний хохирлыг арилгах, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах.

### **Тав. Комиссын гишүүний эрх, үүрэг**

5.1. Комиссын гишүүн нь дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.1.1. комиссын хуралдаанд биечлэн оролцож, өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах;

5.1.2. комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

5.1.3. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаатай танилцах, зөвлөгөө өгөх, тавьсан санал, хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, гүйцэтгэсэн ажлынхаа тайланг комисст тайлагнах.

### **Зургаа. Комиссын зардал**

6.1. Комиссын үйл ажиллагааны зардлыг Ерөнхий сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

### **Долоо. Бусад зүйл**

7.1. Комисс нь үйл ажиллагааныхаа тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулна.



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2009 оны 12 дугаар  
сарын 23-ний өдөр

Дугаар 371

Улаанбаатар  
хот

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах  
үндэсний хөтөлбөрийг батлах тухай**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.28-д заасныг  
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон шаардагдах хөрөнгийг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж, хөтөлбөрт хамруулан санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт үүрэг болгосугай.

4. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж дүнг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөв газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

## ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

#### 1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноор хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал илүү хурцаар тавигдаж, хэрэглэгчийг төлөөлөн ажиллах анхны бүтэц болох төрийн бус байгууллага буюу Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг 1990 онд байгуулагдсан.

1991 онд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталж, 1992 онд Монгол Улсын Засгийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейгаас сайшаан дэмжсэн "Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчим"-ыг хүлээн зөвшөөрч, "Монголын хэрэглэгчдийн эрхийн тухай тунхаг"-ийг 1993 онд баталсан. Улмаар 2003 онд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн үндэс бий болсон.

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.28-д "үндэсний бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, экологийн аюулгүй орчныг бүрдүүлэх, хэрэглэгчийг чанартай, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэх ажлыг эрс сайжруулна" гэсэн зорилт дэвшүүлсэн нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Түүнчлэн хүний хөгжил, хүн амын есөлтийг хангах, нийгмийн таатай орчин бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр жигд, хүртээмжтэй хангах зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг өнөөг хүртэл Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо болон орон нутгийн нийгэмлэгүүд хариуцан ажиллаж ирсэн болно.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага нь хэрэглэгчийн эрх хөндөгдсөн маргаан, гомдлыг мэргэжлийн хяналтын байгууллага зэрэг холбогдох төрийн байгууллагад уламжлан, тухай бүр хамтран ажиллаж, мөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээс хэрэглэгчдэд ээлтэй байдлыг



бүрдүүлэхэд нөлөөлөх урамшууллын ажлыг зохион байгуулж ирсний үр дүнд хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэж, зах зээлийг шударга өрсөлдөөнтэй байлгахад зохих хэмжээний дэмжлэг болж иржээ.

Гэвч сүүлийн 20 жилийн хугацаанд хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлийн хуулийн хэрэгжилт үндэсний болон орон нутгийн хэмжээнд хангалтгүй, уг чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, салбар нэгжийн хувьд үйл ажиллагааны чадавхи бүрдэхгүй байсаар байгаа нь энэхүү асуудлыг шийдвэрлэх шаардлага бий болсныг харуулж байна.

Эдийн засгийн хямрал болон иргэдийн худалдан авах чадвар муу байгаа нь нийгэмд хуурамч, чанарын шаардлага хангахгүй бараа, ажил, үйлчилгээ ихээр гарах нөхцөл бий болж, улмаар хэрэглэгч зах зээлээс эрэлт хэрэгцээндээ нийцүүлэн хямд, аюулгүй, чанартай бараа, ажил, үйлчилгээ сонгон авах боломжийг бууруулж байна.

Монгол Улсын иргэн бүрийн эрх ашгийг хамгаалах, улмаар худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүн, мэдээлэл хангамж зэрэг бүх салбарт хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд хор хөнөөлгүй, хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй тогтолцоо бий болгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг шинэ шатанд гаргах шаардлага бий болж байна.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зарчим, зорилтууд**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь хэрэглэгчдийн эрхийг хамгаалах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, хэрэглээний соёл, хэрэглэгчийн эрхийн тухай мэдлэг, боловсрол олгох, тэдний эрхийг хамгаалах, уг үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог дээшлүүлэхэд оршино.

### **2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим**

2.2.1. худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн бүхий л салбарт "ХЭРЭГЛЭГЧ-ХААН" гэсэн зарчмыг баримтлах;

2.2.2. иргэдийн хэрэглээний соёл, хэрэглэгчийн эрхийн тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд түлхүү анхаарал хандуулах;

2.2.3. хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр иргэд, төрийн бус байгууллагын бүтээгч санал, санаачилгыг төрөөс дэмжиж, ил тод байдлыг эрхэмлэх;



2.2.4. хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үр ашигтай, шинэлэг бүхий л арга хэлбэрийг дэмжих, хөрөнгийг оноентой, үр өгөөжтэй зарцуулах.

### 2.3. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

2.3.1. хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

2.3.2. хэрэглэгчдэд мэдээлэл, зөвлөгөө өгч тэдний хэрэгцээ шаардлагад нь нийцсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх;

2.3.3. хэрэглэгчдийн эрх ашиг түгээмэл хөндөгддөг салбарт тавих хяналтыг сайжруулах;

2.3.4. хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад төрийн болон төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх.

## Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид хэрэглэгчийн эрхтэй холбоотой асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.1.2. хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, олон улсын жишигт нийцсэн шаардлага, стандарт боловсруулж батлуулах;

3.1.3. хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажлыг нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, тодорхой салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага нь уг асуудлыг хариуцсан төрийн байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бий болгох;

3.1.4. үйлдвэрлэл, үйлчилгээг хаалттай орчинд явуулах, бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хэрэглэгчийн зүгээс тавих

хяналтыг сааруулж байгаа зөрчлийг арилгах чиглэлээр эрх зүйн орчинг бүрдүүлэх.

3.2. Хэрэглэгчдэд мэдээлэл зөвлөгөө өгч, хэрэгцээ шаардлагад нь нийцсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хэрэглээний соёл, хэрэглэгчийн эрхийн тухай агуулгыг тусгах;

3.2.2. хэрэглэгчийн боловсрол, соёлыг дээшлүүлэх, сургалт сурталчилгааны арга хэмжээ тогтмол зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх;

3.2.3. хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх, дадлагажуулж, тэдгээрт зориулсан сургалт зохион байгуулах, гадаад орнуудад болон олон улсын байгууллагын зүгээс зохион байгуулж байгаа сургалт семинарт хамруулах, туршлага судлуулах, гадаад харилцааг хөгжүүлэх;

3.2.4. хэрэглэгчийн санал гомдлыг хүлээн авах, зөвлөгөө, зөвлөмж өгөх тусгай зориулалтын нээлттэй утас ажиллуулах, "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдөр"-ийг тэмдэглэхдээ олон нийтэд хандсан хөдөлгөөн, аяныг аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшүүлэх;

3.2.5. аж ахуйн нэгжийн худалдаа, үйлчилгээний цэг, салбаруудад бараа, үйлчилгээнийхээ талаар хэрэглэгчдийг үнэн бодит мэдээллээр хангах зорилго бүхий "Хэрэглэгчийн булан"-г байгуулж ажиллуулах;

3.2.6. хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;

3.2.7. Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо, аймаг, нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн сургалт, сурталчилгаа, хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх чадавхийг бэхжүүлэх;

3.3. хэрэглэгчдийн эрх ашиг түгээмэл хөндөгддөг салбарт тавих хяналтыг сайжруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. худалдаа, үйлчилгээний салбар, тухайлбал: хүнсний дэлгүүр, зах, зоогийн газар, зочид буудал, саун, үсчин, гоо сайхны газар, ахуйн үйлчилгээ, нийтийн тээврийн газарт холбогдох стандарт, техникийн нөхцөл, эрүүл ахуй, ариун цэврийн норм нормативыг мөрдүүлж, хэрэглэгч нэг бүрт хандсан соёлч, боловсон үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.2. барилга, нийтийн аж ахуйн салбарт барилгын чанар, талбайн хэмжээг тооцох аргачлал, барилгын зар мэдээлэл болон орон сууцны конторын үйл ажиллагааг хэрэглэгчдийн шаардлага, цаг үеийн бодит байдалд нийцүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.3. мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн салбарт компьютер, түүний дагалдах хэрэгсэл, интернэт үйлчилгээ болон гар утас, түүний дагалдах хэрэгсэл, цахилгаан хэрэгслийн худалдааг олон улсын стандарт жишигт нийцүүлэх;

3.3.4. хүнсний бүтээгдэхүүний салбарт, тухайлбал: талх, нарийн боов, сүү, сүүн бүтээгдэхүүн, ус, ундаа, архи, согтууруулах ундаа, мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ зэрэг бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах;

3.3.5. борлуулж байгаа импортын эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зааврыг монгол хэл дээр гаргах, хувийн эмнэлэг, рашаан сувилал, амралтын газруудын үйлчилгээний орчин, нөхцөлийг сайжруулах;

3.3.6. гадаад хэл болон мэргэжлийн сургалтын төвүүд, соёл урлаг, үзвэрийн газрын үйлчилгээний орчин, нөхцөлийг сайжруулах;

3.3.7. банк, санхүү, даатгалын салбарт хэрэглэгчийг хохироохоос урьдчилан сэргийлж, борлуулж байгаа бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хяналт тавих;

3.3.8. бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зар сурталчилгааг бодит байдалд нийцүүлж, хэрэглэгчийг төөрөгдүүлсэн болон худал ташаа мэдээллээс тэднийг хамгаалах механизмыг бүрдүүлэх;

3.3.9. хүнсний болон бусад төрлийн бараа бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн шаардлага хангаж байгаа эсэхэд анхан шатны чанар, аюулгүй байдлын шинжилгээ хийх зориулалт бүхий хөндлөнгийн лаборатори байгуулах;

3.3.10. стандартын шаардлага хангахгүй болон хуурамч бараа, бүтээгдэхүүн, эм, бэлдмэлийн хэрэглээг хязгаарлах, улсын хилээр нэвтрүүлэхгүйгээр устгах, эсхүл буцаан гаргаж байх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагууд идэвхтэй хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх;

3.3.11. аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо бүрт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус шинжээч, сайн дурын ажилтан ажиллуулах, тэднийг ажлын үр дүнгээр нь урамшуулах механизмыг бий болгох.

3.4. Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад төрийн болон төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд харилцан мэдээлэл солилцох нэгдсэн цахим сүлжээ бий болгох;

3.4.2. хэрэглэгч эрхээ хамгаалуулах үйл ажиллагаанд саад учруулж байгаа төрийн захиргааны болон аж ахуйн нэгжийн шийдвэрийг хянуулах, шаардлагатай гэж үзвэл хүчингүй болгуулах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.4.3. үйл ажиллагаагаа хэрэглэгчийн өмнө ил тод, нээлттэй явуулдаг, итгэлтэй бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллах.

3.5. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. яам, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага:

-хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаархи хууль тогтоомж болон салбарын бусад хуулийн хэрэгжилтийг хангуулах;

-хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хамтран ажиллах.

3.5.2. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

-үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, дүнг нэгтгэн нийтэд мэдээлэх;

-сум, дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагуудыг бүхий л талаар дэмжиж, бүтээгдэхүүн нийлүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулах.

**3.5.3. хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллага:**

-хэрэглэгчийн санал хүсэлтийг нэгтгэн илэрхийлэх, хэрэглэгчдийн нийгмийн өмнө хүлээх үүргийг дээшлүүлэн идэвхжүүлэгч, санаачлагч, зохион байгуулагч нь байх;

-олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, хэрэглэгчдийн талаар судалгаа хийх, дүнг нийтэд мэдээлэх;

-хэрэглэгчдэд эрхээ хэрэгжүүлэх мэдлэг, хэрэглээний соёл эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулах;

**3.5.4. хувийн хэвшил, аж ахуйн нэгж, байгууллага:**

-бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж болон холбогдох хуулинд заасан эрх, үүргийг чанд мөрдөж ажиллах;

-хэрэглэгчийг "ХААН"-д өргөмжилж, зохистой үнэ бүхий, чанарын шаардлага хангасан, хэрэглэгчийн амь насанд аюулгүй, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр хангах;

-ажил, үйлчилгээндээ дэвшилтэд арга технологи нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа хэрэглэгчдэд ил тод нээлттэй байлгах;

-аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх.

**Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хугацаа, санхүүжилт**

**4.1. Удирдлага, зохион байгуулалт, хяналт**

4.1.1. хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага хамтран хэрэгжүүлнэ;



4.1.2. аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд Хэрэглэгчийн эрхийн зөвлөл байгуулан ажиллуулж болох бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд орон нутгийн хэрэглэгчийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оруулж болно.

4.2. Хөтөлбөрийг 2010-2012 оны хооронд хэрэгжүүлнэ.

4.3. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

4.3.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

4.3.2. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

4.3.3. олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

4.3.4. бусад эх үүсвэр.

#### **Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд**

5.1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

5.1.1. Эрх зүйн орчны чиглэлээр:

-хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин сайжирсан байна;  
-олон улсын гэрээ, конвенцийн дагуу стандарт, хэм хэмжээ, бусад шаардлагууд батлагдсан байна.

5.1.2. Сургалт, сурталчилгааны чиглэлээр:

-хэрэглэгчийн хэрэглээний соёлын талаархи мэдлэг, хандлага дээшилсэн байна;  
-хэрэглэгчид сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөх тогтолцоо бүрдсэн байна;  
-аймаг, нийслэл, дүүрэгт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах салбар нэгжүүдийн үйл ажиллагааны чадавхи бэхжсэн байна;  
-гадаадын хандив, буцалтгүй тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжиж хэрэглэгчийн эрхийг хамгаалах шинэлэг арга, хэлбэр бий болсон байна.



5.1.3. Хэрэглэгчийн эрх түгээмэл хөндөгддөг салбаруудын чиглэлээр:

-хэрэглэгчийн эрх түгээмэл зөрчигдөж болзошгүй худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний бүхий л салбаруудын ажил, үйлчилгээний чанар, хүртээмж шаардлага хангах түвшинд хүрсэн байна;

-өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнд шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг, төрийн бус байгууллагын оролцоонд түшиглэсэн, хараат бус, хөндлөнгийн лаборатори байгуулж шинжилгээ хийх боломж бүрдсэн байна.

5.1.4. Төрийн болон төрийн бус байгууллагын чиглэлээр:

-хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллагуудын оновчтой тогтолцоо бий болж, боловсон хүчний болон үйл ажиллагааны чадавхи бэхжсэн байна;

-төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа идэвхижиж үйл ажиллагааны болон санхүүгийн хувьд бэхжсэн байна.

-хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чадавхи дээшилсэн байна.

5.2. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

5.2.1. хөтөлбөрт тусгагдсан эрх зүйн орчны хэрэгжилт;

5.2.2. хэрэглэгчийн мэдлэг, хэрэглээний соёлыг дээшлүүлэх чиглэлээр хийгдсэн сургалт, сурталчилгааны ажлын тоо, чанар, хэрэглэгчдийн боловсролын түвшин;

5.2.3. хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хэрэглэгчийн эрх түгээмэл зөрчигддөг салбаруудад худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд гарсан чанарын өөрчлөлт;

5.2.4. хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл гомдлын тоо, түүний барагдуулалт, хэрэглэгчийн эрх ашгийг хохироосон болон хууль зөрчсөн аж ахуй нэгж, тэдгээрт хүлээлгэсэн захиргааны хариуцлагын дүн болон бусад эдийн засгийн үзүүлэлт;

5.2.5. хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ тухайн жилийн нийгэм, эдийн засгийн байдал, зах зээлийн төлөв байдал зэргийг харгалзана.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Сэнхүү-жилтийн эх үүсвэр	Шаардагдах хөрөнгө (сая.төг)			
				2010 он	2011 он	2012 он	Бүгд
Нэг. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар							
1.1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судалгаа хийх, олон улсын эксперт ажиллуулах, санал боловсруулах, батлуулах	ХЗДХЯ, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар		-	-	-	-
1.2	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх	ГХЯ, ШӨХТГ, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо		-	-	-	-
1.3	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын оролцоог тодорхой заасан шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	ЗГХЭГ, ШӨХТГ		-	-	-	-



1.4	Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн зах зээлд нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үйлдвэрлэл, борлуулалт, технологийн процесс нь хэрэглэгчдэд ил тод, нээлттэй байх эрх зүйн орчинг бүрдүүлэх	ХЗДХЯ						
Хоёр. Хэрэглэгчдэд мэдээлэл, зөвлөгөө өгч, хэрэгцээ шаардлагад нь нийцсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд								
2.1	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хэрэглээний соёл, хэрэглэгчийн эрхийн талаархи агуулыг тусгах чиглэлээр санал боловсруулж шийдвэрлүүлэх	БСШУЯ, ШӨХТГ						
2.2	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага болон бүсийн төвүүдэд хэрэглэгчийн боловсрол, соёлыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааны арга хэмжээ тогтмол зохион байгуулах, мэдээллээр хангах боломжийг бүрдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах	ШӨХТГ, МХЗАХНУХ	35.0	35.0	70.0	140.0		



2.3	<p>Хэрэглэгч шаардлагатай мэдээллээ хүссэн цагтаа авч, санал гомдлоо чөлөөтэй илэрхийлж, шуурхай шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор цахим сүлжээ байгуулах, "Хэрэглэгчийн утас"-ыг ажиллуулан тэдний санал бодлыг сонсож, мэдээлэл зөвлөгөө тогтмол өгч байх боломжийг бүрдүүлэх</p>	ШӨХТГ	15.0	15.0	-	30.0
2.4	<p>Хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх зорилгоор орон нутагт сургалт, сурталчилгааны төвлөрсөн арга хэмжээг улирал бүр тогтмол зохион байгуулах</p>	ШӨХТГ, МХЭАХНҮХ	10.0	10.0	10.0	30.0
2.5	<p>Хэрэглэгчид зориулсан гарын авлага, ном, товхимол, зурагт хуудас, сурталчилгааны бусад материал бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээх</p>	ШӨХТГ	5.0	10.0	10.0	25.0
2.6	<p>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, журам заавар, аргачлалыг гарын авлага болгон бэлтгэж хэвлүүлэх</p>	ШӨХТГ	-	5.0	5.0	10.0

2.7	Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах сүлжээ байгууллага (ISPREN), Олон улсын эдийн засаг, хөгжил, хамтын ажиллагааны байгууллагын дэргэдэх Хэрэглэгчийг хамгаалах хороо (OECD CPC) зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах, гишүүнээр элсэх асуудлыг судалж шийдвэрлэх	ГХЯ, ШӨХТГ, МХЭАХНУХ		-	-	-	-
2.8	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага, ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр олон улсын болон гадаад орнуудын ижил төстэй байгууллагын дэмжлэг тусалцааг авах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	ГХЯ, ШӨХТГ		20.0	20.0	20.0	60.0
2.9	"Хэрэглэгчийн эрхийг хамгаалах" олон улсын өдрийг угтан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд "Хэрэглэгчийн төлөө" сарын аяныг улс даяар зохион байгуулж хэвшүүлэх	ШӨХТГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ		-	-	-	-
2.10	Бизнес эрхлэгчид үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ байранд хэрэглэгчдэд зориулсан мэдээллийн самбар, буланг тогтмол ажиллуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	ШӨХТГ, аж ахуй эрхлэгчид		-	-	-	-

2.11	Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооноос зохион байгуулж байгаа хэрэглэгчдэд таашаагдсан "Монгол брэнд" шалгаруулах үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжиж, хамтран ажиллах	ШӨХТГ	-	-	-	-
2.12	Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байгаа хэвлэл, мэдээллийн байгууллага, аж ахуйн нэгжийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, урамшуулах, хөхиүлэн дэмжих	ШӨХТГ	6.0	6.0	6.0	18.0
Гурав. Хэрэглэгчийн эрх ашиг түгээмэл хөндөгддөг салбаруудад тавих хяналтыг сайжруулах зорилтын хүрээнд						
3.1	Хэрэглэгчийн эрх түгээмэл эерчигдөж болзошгүй худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг жил бүр тогтоож, тэдгээрийн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтын механизмыг бүрдүүлэх	ШӨХТГ	-	-	-	-
3.2	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнд шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг, олон нийтийн байгууллагын оролцоонд түшиглэсэн, хараат бус, хөндлөнгийн лаборатори байгуулах боломжийг судалж шийдвэрлүүлэх	ШӨХТГ	-	150.0	30.0	180.0

Дөрөв. Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад төрийн болон төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

4.1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, харилцан мэдээлэл солилцох нэгдсэн цахим сүлжээ (вэб сайт) бий болгох	ШӨХТГ	10.0	-	-	-	10.0
4.2	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож, үйл ажиллагааны давхардлыг арилгах	ШӨХТГ	-	-	-	-	-
4.3	Төрийн бус байгууллагуудын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, үйл ажиллагааны үр дүн, үр өгөөжийг үнэлж дүгнэдэг арга, механизмыг боловсронгуй болгон сайжруулах	ЗГХЭГ, ШӨХТГ	-	-	-	-	-
4.4	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон орон нутгийн төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр төсөл боловсруулж хэрэгжүүлэх	ШӨХТГ, ОУБ	20.0	20.0	20.0	20.0	60.0



4.5	Хэрэглэгчийн амь насанд аюулгүй, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй бараа борлуулж, ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, хэрэглэгчээ дээдэлж, хүндэтгэлтэй ханддаг бизнес эрхлэгч, хэрэглэгчийн эрэлт шаардлагад нийцсэн чанартай бараа, ажил үйлчилгээг шалгаруулж урамшуулах	ШӨХТГ, МХЭАХНҮХ, аймаг, нийслэлийн Засаг дарга нар	-	-	-	-	121.0	271.0	171.0	563.0		
							Улсын төсвөөс				225.2 (40%)	
Бүгд дүн		Урсгал		Урсгал		Урсгал		Урсгал		Орон нутгийн төсөв		
										ХЭАХНҮХ болон бусад олон нийтийн байгууллага		90.0 (16.0%)
										ОУБ-ын төсөл, хөтөлбөр, тусламжийн хөрөнгө		168.9 (30.0%)
Үүнээс (сая.төг)												

**Хаяг:**

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin\_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвцэлийн хуудас 1.5

Индекс: 14003